

МАНЛАЙ СУМЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

БАТЛАВ.

 Т. БАТ-ЭНХ

2024 оны 05 дугаар сарын 08 өдөр

НАРНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР АЖИЛЛАДАГ УС ӨРГҮҮРИЙГ ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ХУДАГТ СУУРИЛУУЛАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Байршил: Өмнөговь аймгийн Манлай сум Өехий баг “Алтгана”, Өгөөмөр баг “Гүн баян”, Жаргалант баг “Ташаа”, Далай баг “Шинэ ус”
2. Ажлын тодорхойлолт: Бэлчээр усжуулалтанд зориулж инженерийн хийцтэй худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг шинээр суурилуулна.

Манлай сумын нутаг дэвсгэрт байрлах инженерийн хийцэт худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг сонгон суурилуулах ажилд тухайн ажилд тавих техникийн шаардлага стандартыг мөрдлөг болгон доорхи нөхцөлийг хангаж ажиллана. Үүнд:

1. Худагт нарны эрчим хүчээр ажилладаг нарны зай, ус өргүүр, цэнэг хураагуур сонгон суурилуулах, суурилуулсан тоног төхөөрөмж нь 50-150 хүртэл метр гүнээс ус татах хүчин чадал бүхий нэг цагт 3,0-3.5 тн-оос багагүй ус гаргах хүчин чадал бүхий ус өргүүртэй, өдөрт 6 цагаас багагүй хугацаагаар ажиллах боломжтой, 1,5 жилийн чанарын баталгаат хугацаатай байна. Гүн өрмийн худагаас ус өргөх ажиллагаанд хурдтай хөгжиж байгаа шинжлэх ухаан техникийн дэвшлийг ашиглаж одоогийн шийдлээс давуу талтай, малчдын гүний худаг ашиглах нөхцлийг хөнгөвчилж мөнгө хөрөнгө хэмнэсэн шинэлэг инновацийн төхөөрөмж ашиглан шийдсэн байж болно. Малчид нарны ус өргүүрээ илүү сайн хэмнэлттэй ашиглахад дөхөм болгосон шинэлэг санал, төхөөрөмжөөр шийдсэн ашиглалтын зардал хямд байх зэрэг давуу талыг хангасан байвал сайн. Шинэлэг санаа, технологийг говийн нөхцөлд туршиж баталсан байвал сайн гэж үзнэ.
2. Худгийн цооногт шавхалт туршилтын ажил хийж, худгийн гүн, ундарга, статик, динамик түвшин зэргийг бүрэн тодорхойлсны дараа нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг сонгон авч угсрах, ажиллагааны зарчмын хувьд нарны толиноос ус өргөх насосыг ажиллуулах, нарны зайг шөнийн цаг, бүрхэг өдөр ашиглахаар тоноглох, нарны зай, цэнэг хураагуурын хүчдэл ижил байх.
3. Нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүр, нарны зай, цэнэг хураагуур зэрэг тоног төхөөрөмжүүд нь 2017 оноос хойш үйлдвэрлэгдсэн, үйлдвэрлэгчийн нэр хаяг тодорхой, барааны Олон улсын ISO-9001 стандарттай байх, Барааны гарал, үүслийн тодорхойлолт, Тухайн компанийн бараа үйлдвэрлэх эрхийн бичиг, Нийлүүлэх барааны техникийн үзүүлэлтийг нотолсон үйлдвэрлэгч компанийн хэвлэмэл танилцуулга, ашиглалтын заавар, Ашиглалтын зааврыг Монгол хэл дээр бэлтгэсэн байна. Нарны толь 200w-аас доошгүй, худгийн гүнээс шалтгаалан 4-оос доошгүйг суурилуулах, нарны зай нь 200а/цаг багагүй чадалтай, 4-оос доошгүй, инвертертэй байна. Шинэ шийдлээр санал болгож Малчдын хөдөлмөр хөнгөвчлөн ус өргөх ашиглах ажиллагааг их хялбарчилсан малчдын ашиглалтын зардлыг хэмнэсэн шинэ техникүүд байж болно.
4. Нарны дэлгэцийг тусгай төмөр суурь гагнан бэлтгэж, нар дагаж эргэхээр хөдөлгөөнтэй суурилуулах, хөлийг газарт цутгаж бэхлэнэ. Салхи шуурганы хамгаалалт хийнэ.
5. Ус өргүүрийг суурилуулсаны дараа худгийг цооногийг түр хугацааны битүүмжлэл хийх
6. Нарны зайн дэлгэц, нарны дэлгэцийг бэхлэх суурь, тулгуур, цахилгаан холболтын утаснуудыг хамгаалсан хашааг 1,5 м-ээс багагүй өндөртэй, төмөр шон нь 40 мм-ийн диаметрээс багагүй, шон тус бүрийг цемент цутгаж бэхлэсэн, зэвэрдэггүй ган утсаар хийсэн сайн чанарын төмөр торон хашаатай, ган утас ф 10 мм-ээс багагүй, нүхний хэмжээ 4-5 см-ээс хэтрэхгүй хийж, нарны толийг мал хүрэхээс хамгаалж, худгийн барилгын гадна талаар барих
7. Мал услах онгоц, талбайг шинээр байгуулах. Мал услах онгоцны хэмжээ 9 м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой, хагас цилиндр, ган хоолой буюу цутгамал төмөр бетон, ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засах, худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2 м-ийн зайд байрлуулна. Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргаж, нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ. Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн ероолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана. Мал услах талбайн хэмжээ нь онгоцны уртын дагуу 2 талдаа 1 м-ийн өргөнтэй, 10 см зузаан, материал нь 150 маркаас доошгүй цемент хэрэглэж, талбайг хийхдээ төмөр тороор хүчитгэж өгнө.

8. Ажлын явцад техник хяналтыг тогтмол хийлгэж, ажил дуусахад талбайг цэвэрлэх, ашиглагчид худгийн эзэмшил ашиглалтын талаар сургалт хийж, заавар өгч, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн акт үйлдэх
9. Худгийн техникийн паспортыг хөтөлж сумын ЗДТГазарт, худаг орчмын малчдын бүлэг, багийн Засаг дарга нарыг байлцуулан худаг хүлээх авах аймгийн болон сумын комисст хүлээлцэх, комиссын дүгнэлт гаргуулах.
10. Гүн өрмийн хуудуудыг шинэчлэн тоноглогсны дараах ашиглалтын болон засвар үйлчилгээ хийх тодорхой төлөвлөгөө гаргасан, гэмтэл саатал гарсан тохиолд яаралтай засч ашиглалтад бэлэн байлгах боломжтой байх нь давуу тал болно.